



ОНЧ ШИЙДЭЛ ТББ

АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗДТГ, ТӨРИЙН ӨМЧИЙН БОЛОН ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН
ҮНЭЛГЭЭ

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот,
2013 оны 12 сарын 05-ны өдөр

1. Удиртгал
2. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН”
 - 2.1. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ
 - 2.2. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
 - 2.3. ОЛОЛТ, АМЖИЛТ
 - 2.4. НИЙТЛЭГ ДУТАГДАЛТАЙ ТАЛ
 - 2.5. ТЭРГҮҮН ТУРШИЛГА
 - 2.6. СУДАЛГААНЫ ДҮН
 - 2.7. ДҮГНЭЛТ
3. ХОЁРДУГААР БҮЛЭГ “ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ”
 - 3.1. ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ
 - 3.2. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
 - 3.3. ОЛОЛТ АМЖИЛТ
 - 3.4. НИЙТЛЭГ ДУТАГДАЛТАЙ ТАЛ
 - 3.5. ТЭРГҮҮН ТУРШИЛГА
 - 3.6. СУДАЛГААНЫ ДҮН
 - 3.7. ДҮГНЭЛТ
4. САНАЛ, ЗӨВЛӨМЖ
5. ХАВСРАЛТУУД

УДИРТГАЛ

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын захиалгаар АНУ-ын Азийн сангийн “Монгол Улсад Засаглал, Ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн хүрээнд хөндлөнгийн шинжээчдийн баг нийслэл болон 21 аймгийн ЗДТГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тайланг бэлтгэн гаргав.

Үнэлгээг хөндлөнгийн судлаачдын баг Авлигатай тэмцэх газраас гаргасан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны ажлын тайлан нь санхүүжүүлэгч АНУ-ын Азийн сан болон Авлигатай тэмцэх газрын байр суурь, саналыг агуулаагүй бөгөөд зөвхөн хөндлөнгийн судлаачдын үнэлгээний ажлын үр дүн болно.

Зорилго:

Аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт өгч үнэлгээний үр дүнгээр жагсаалт гаргах, тэдгээрийн ололт амжилт, нийтлэг алдаа дутагдлыг тодорхойлох, зарим тэргүүн туршилгыг онцлох, цаашид төрийн байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

1. Тухайн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх;
2. Сонгосон байгууллагуудад газар дээр нь ажиллаж үнэлгээг баталгаажуулах
3. Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагуудын 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарсан ололт үр дүн, тэргүүн туршлага, алдаа дутагдлыг тодорхойлох;
4. Авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах талаарх санал, зөвлөмжийг дэвшүүлэн гаргахад зэрэг зорилгыг дэвшүүлэв.

Хамрах хүрээ:

Хорин нэгэн аймаг болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дөчин найман аж ахуйн нэгжүүдийн иүүлсэн 2013 оны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, холбогдох нотлох баримтын хүрээнд тус үнэлгээг хийж гүйцэтгэв.

Хугацаа:

2013 оны 11 сарын 15-наас 2013 оны 12 дугаар сар 5-ны өдөр хүртэлх ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Арга зүй:

Үнэлгээг Авлигатай тэмцэх газраас батлан гаргасан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Тус үнэлгээг баримт бичиг судлах, цахим хуудас холбогдох мэдээллийн эх сурвалжид шинжилгээ хийх, ажилчин албан хаагчдаас асуулгын судалгаа авах,

газар дээр нь ажиллаж ажиглалт дүгнэлт хийх зэрэг судалгааны аргуудыг ашиглан хийж гүйцэтгэв.

Үнэлгээ, шинжилгээнд ашигласан эх сурвалж

- Дээрх байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллаганы төлөвлөгөө тайлан, хавсралтаар ирсэн нотлох баримтууд,
- Байгууллагын цахим хуудас,
- Газар дээр нь ажиллаж гаргуулан авсан баримт, нотолгоо,
- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн бүртгэл,
- Авлигатай тэмцэх газраас авагдсан зөрчил арилгуулах, хариуцлага оногдуулсан арга хэмжээний бүртгэл,
- Тухайн байгууллагуудтай холбогдох авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэл,
- Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагын албан тушаалтнаас Авлигатай тэмцэх газарт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа бүртгэлийн тоо мэдээ,
- Асуулгын судалгааны дүн,
- Төрийн албаны зөвлөл болон худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас.

Үнэлгээний ажлын зохион байгуулалт:

“Онч шийдэл” ТББ нь АТГ, АНУ-ын Азийн сан нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд сонгон шалгаруултад тэнцэж хуульч судлаач Ө.Эрдэнэ-Очир, А.Зоригтбаатар, Ш.Алтангадас, Т.Багахүү нараас бүрдсэн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр энэхүү ажлыг гүйцэтгэсэн бөгөөд шинжээчдийн баг дүн шинжилгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө гарган, түүний дагуу хийж гүйцэтгэв.

Шинжээчдийн баг доорх зарчмыг удирдлага болгон ажиллав. Үүнд:

- Төрийн болон бусад байгууллагаас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүйгээр судалгааны ажлыг гүйцэтгэх;
- Бодит мэдээлэл, нотлох баримтанд тулгуурлан шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх;
- Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагуудад тэгш байдлаар хандах;
- Үнэлгээний чанарыг сайжруулах, баталгаажуулах зорилгоор санамсаргүй сонголтын зарчимаар газар дээр нь очиж ажиллах;

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудаас

Үнэлгээний бодит байдал, хамрах хүрээ, чанарыг баталгаажуулахын тулд Аймаг нийслэлийн ЗДТГ-уудаас аймгуудыг бүсчилсэн байдлаар нь хуваарилж тухайн бүсээс санамсаргүй сонголтоор тус бүр нэг нийт дөрвөн аймгийг сонгон авч газар дээр очиж, бодит нөхцөлд нь ажиллаж үнэлгээ хийсэн болно. Үүнд:

- Баруун бүс- Баянхонгор аймаг
- Төвийн бүс- Дархан-Уул аймаг
- Говийн бүс- Өмнөговь аймаг

- Зүүн бүс- Дорнод аймаг

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагуудаас

Хөдөө орон нутагт байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг, нийслэлд байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага гэсэн шинжээр нь шалгуур үзүүлэлт болгон үнэлгээний дүнг баталгаажуулах зорилгоор нийт дөрвөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын газар дээр нь очиж бодит нөхцөл байдалд нь үнэлгээ хийх, тайланд дурьдсан нотлох баримтуудыг гаргуулан авах зэргээр ажиллав. Үүнд:

- Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага
 - Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ ТӨХК
 - Өмнөговь аймгийн Цөм сүрэг үржлийн аж ахуй
- Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага
 - Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
 - ҮЦГТТХ-ын төв ТӨК
 - Улаанбаатар төмөр зам нийгэмлэг

НЭГДҮРГЭЭР БҮЛЭГ .

НИЙСЛЭЛ БОЛОН АЙМГУУДЫН ЗДТГ-ЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НИЙСЛЭЛ БОЛОН АЙМГУУДЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ҮНЭЛГЭЭ

Нийт 21 аймаг, нийслэлийн ЗДТГ-ын 2013 онд авлигын эсрэг явуулсан үйл ажиллагааг үнэлэн, дүгнэлт өглөө. Үнэлгээг хийх явцад тухайн байгууллага авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ АТГ-ын шаардсаны дагуу холбогдох нотлох баримтыг бүрэн дүүрэн хүргүүлээгүй нь хүндрэлтэй байлаа.

Үнэлгээг хийхдээ тайланд тусгасан бол тухайн тайланг худал гэж үзэх үндэслэл байхгүй учраас хэдийгээр нотлох баримтыг ирүүлээгүй ч харгалзах оноог өгсөн болно.

Мөн тайланд хийж хэрэгжүүлсэн, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан гэж тайлагнасан боловч цахим хуудсанд шинжилгээ хийхэд тухайн мэдээлэл байршаагүй бол харгалзах оноог өгөхөөс татгалзсан болно. Тайланд тусгагдаагүй хэдий ч нотлох баримтаар ирүүлсэн мөн газар дээр нь биечлэн ажиллах явцад хийгдсэн нь тодорхой болсон бол тайлагналт муу байсан нь ажил муу гэх үндэслэл болохгүй гэж үзсэний үнсэн дээр тухайн ажлуудыг холбогдох нотлох баримтыг нь гаргуулан авах, бодит байдлыг нь гэрэл зургаар баталгаажуулж авах зэргээр нотлогооны эх сурвалж болгон бүрдүүлж харгалзах оноог өгсөн болно.

Үнэлгээний ажлын гол эх сурвалж болсон Авлигатай тэмцэх газраас боловсруулан гаргасан “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын харгазах үзүүлэлт дотор дурьдагдсан хэд хэдэн ажлаас тухайлсан нэгийг нь гүйцэтгэсэн байх эсвэл хоёр ажлыг нь гүйцэтгэж нэгийг нь орхигдуулсан зэрэг тохиолдолд оноог хувааж, аравтын бутархай руу шилжүүлэн өгсөн болно.

Тухайн байгууллагын онооны нэгдсэн дүн гарахад оноог ойлгомжтой тодорхой болгох үүднээс бутархай тоог 0,5-аас дээш бол дээш шилжүүлэх, 0,5-аас доош бол доош шилжүүлэх зарчмыг баримтлан дүнг гаргасан.

“Үнэлгээний аргачлал”-ын тухайн байгууллагад хамааралгүй буюу үнэлэхгүй хэсгийг Авлигатай тэмцэх газартай зөвлөлдөж тодорхойлсон. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд үнэлгээний аргачлалын 7.1.1, 7.1.6-ийн концесстой холбогдох хэсгийг үнэлээгүй бөгөөд тухайн хэсгүүдэд харгалзах оноог тэнцэтгэлийн зарчимаар нийт авах ёстой 70 оноонд харицуулан эцсийн оноог гаргасан болно.

Үнэлгээ хийхэд 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй хоёр аймаг байсан ба тэдгээрийн цахим хуудас, өөр үнэлгээнд ашиглаж болох бусад мэдээллийн эх сурвалж, материалуудыг үндэслэн үнэлгээг хийж харгалзах оноог өгсөн.

2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй аймаг

- Сүхбаатар аймгийн ЗДТГ

- Говьсүмбэр аймгийн ЗДТГ (хагас жилийн тайлан ирүүлсэн)

Үнэлгээний аргачлалын зөрчил илрүүлэлтэй холбогдсон хэсэгт ямар нэгэн зөрчил илрээгүй бол харгалзах оноог бүтнээр нь дотоод хяналтаар зөрчил илрээгүй боловч АТГ-ын шалгалт, бусад иргэдийн мэдээллээр зөрчил илэрч арга хэмжээ авагдсан бол оноо өгөөгүй.

Үнэлгээний аргачлалын 7.3.1–ийн 3 дах хэсэг дэх шалгуур буюу “төрийн байгууллагаын дарга, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал”-ыг АТГ-тай хамтран таван асуулга бүхий судалгааг тухайн байгууллагын ажилчдаас авч тус судалгааны үр дүнгээр харгалзах оноог өгсөн.(Судалгааны үр дүнг хавсаргав.)

Мөн үнэлгээний хүснэгтийн 7.1.20 буюу АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөн байцаагчийн албан даалгавар, мэдэгдэл, албан бичгийн биелэлтээр үнэлэх хэсэгт АТГ-аас хүргүүлсэн дээрх албан бичгүүдийн бүртгэлийг харгалзан албан бичиг хүргүүлээгүй бол харгалзах оноог бүтнээр албан бичиг хүргүүлсэн бол түүний биелэлтээр харгалзах оноог тус тус өгч үнэлсэн.

Үнэлгээний нэгтгэл

№	Аймаг	Оноо
1.	Орхон аймгийн ЗДТГ	82
2.	Дундговь аймгийн ЗДТГ	76
3.	Хэнтий аймгийн ЗДТГ	72
4.	Увс аймгийн ЗДТГ	69
5.	Өвөрхангай аймгийн ЗДТГ	67
6.	Дорнод аймгийн ЗДТГ	67
7.	Өмнөговь аймгийн ЗДТГ	66
8.	Дархан-Уул аймгийн ЗДТГ	59
9.	Нийслэлийн ЗДТГ	58
10.	Говь-Алтай аймгийн ЗДТГ	57
11.	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	57
12.	Төв аймгийн ЗДТГ	56
13.	Дорноговь аймгийн ЗДТГ	55
14.	Булган аймгийн ЗДТГ	54
15.	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	53
16.	Архангай аймгийн ЗДТГ	53
17.	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	45
18.	Баянхонгор аймгийн ЗДТГ	41
19.	Завхан аймгийн ЗДТГ	37
20.	Ховд аймгийн ЗДТГ	34
21.	Хөвсгөл аймгийн ЗДТГ	24
22.	Сүхбаатар аймгийн ЗДТГ	2
Дундаж		51,3

Үнэлгээний дүнг гаргахад Орхон аймаг авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвөлгөө тайланг “Үнэлгээний аргачлал”-ын дагуу зүйл бүрээр нь гаргаж холбогдох нотлох баримтыг хавсарган ирүүлсэн бөгөөд төлөвлөсөн ажлыг шат

дараалан хийж гүйцэтгэсэн, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хангалттай ажилласан, цахим хуудсаны мэдээллийн баяжуулалт байх ёстой мэдээлэл бүрэн дүүрэн, ёс зүйн чиглэлээр мэдээлэл хүлээж авах, бүртгэх зөрчил шийдвэрлэлт боломжийн түвшинд, иргэдээс гомдол мэдээлэл хүлээж авах мэдээллийн олон сувгийг үр дүнтэй ашиглаж байгаа, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр дэвшилт гаргасан гэдэг олон сайн үзүүлэлтээр өндөр оноо авсан байна.

Сүхбаатар аймгийн хувьд 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан боловсруулан ирүүлээгүй. Мөн үйл ажиллагааг үнэлэх материал байхгүй, цахим хуудасны мэдээлэл бүрэн бус, холбогдох мэдээллийг байршуулаагүй, мэдээллийн ил тод байдлыг хангаагүй гэх хариуцлаггүй байдлаас шалтгаалан хамгийн бага оноог авч байна.

Үнэлгээний дүнг баталгаажуулах зорилгоор сонгосон дөрвөн аймгийн ЗДТГ –т томилолтоор ажиллав. Сонголтыг хийхдээ үнэлгээний хамрах хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулах үүднээс Монгол орны бүс бүрээс нэг аймаг сонгон авч бодит нөхцөл байдалтай танилцах, тухайн байгууллын авлигын эсрэг үйл ажиллаганий тайлангийн үнэн зөвийг нягтлах, холбогдох баримтыг гаргуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээрх ажлуудыг хэрхэн хэрэгжүүлж байгааг ажиглаж үнэлэлт өгч ажилласан болно. Дорнод аймгийн ЗДТГ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Баянхонгор аймгийн ЗДТГ, Өмнөговь аймгийн ЗДТГ-уудад ажиллаж, тайлан бичиж хавсаргасан болно. (Хавсралт-2)

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Үнэлгээний үр дүнг нэгтгэн байгууллага бүрийн тухайн шалгуурт авсан оноо гүйцэтгэлийн хувийг гарган тооцож нийт үнэлгээнд дүн шинжилгээ хийж ажилласан болно. (Хавсралт-3)

Аймаг, Нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээний хүснэгт дэх хуулиар хүлээсэн үүргийн биелэлт болон авлигын эсрэг үйл ажиллагааны санал санаачилга, гүйцэтгэлийн дундаж нь 54,3 хувийн биелэлт үнэлгээ авч байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний холбогдох хэсгүүдээс дараах байдлаар үнэлгээ авсан байна.

- ЭБАТ-ын үйл ажиллагаатай холбоотой ажлуудын гүйцэтгэл-61,6%
- Соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны чиглэлийн ажлын гүйцэтгэл- 49,6%
- Иргэдийн оролцоог хангах чиглэлээр- 57,6%
- Дотоод хяналт шалгалт, зохион байгуулалтын чиглэлийн ажлууд- 58,5%
- Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлийн гүйцэтгэл- 53,1%
- Иргэний нийгэмийн байгууллагатай хамтын ажиллагаа чиглэлээр- 53%
- АТГ-ын зөвлөмж, албан бичгийн биелэлт-47%
- Удирдлагын авлигын эсрэг хүсэл, эрмэлзэл хүчин чармайлт- 53%
- Иргэний өргөдөл гомдолын хүлээн авах нөхцөл бүрдүүлэлт, шийдвэрлэх тогтолцоо- 50,8

ХАМГИЙН ӨНДӨР ОНОО, ХУВЬ АВЧ ГҮЙЦЭТГЭГДСЭН АЖЛУУД

- Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал- 90,9%
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт-90,9%
- Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах-79%
- Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл , дараа жилийн төсвийн төсөл цахим хуудсанд байршуулсан байдал-74%
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байдал-68,2%
- Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байдал-88%
- Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдал-72,7%
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан байдал-88,6%
- Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байдал-81,8%
- Тендерийн үнэлгээний хо-рооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал-72,7%
- Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажилласан байдал, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн -86,4%
- Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байдал-81,8%

ХАМГИЙН БАГА ОНОО, ХУВЬ АВСАН АЖЛУУД

- Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлсэн байдал-36,4%
- Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байдал-47,7%
- Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байдал-36,4%
- Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-22,7%
- Тендерт шалгарсанболон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар танилцуулсан байдал-22%
- Тодорхой төрлийн үйл ажил-лагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байдал-30%
- Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал-29%
- АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэ-лийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон ний-гэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлт-18%

ОЛОЛТ АМЖИЛТ

Аймаг, Нийслэлийн ЗДТГ-аас 2013 онд авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ нийтлэг байдлаар зарим ололт, амжилтанд хүрчээ.

- Нийслэл, аймаг бүр “төрийн байгууллагын цахим хуудасны стандарт”-ын дагуу өөрийн цахим хуудсыг ажлуулж тус цахим хуудсаараа дамжуулж мэдээллийг ард иргэд, олон нийтэд түгээх нөхцөл болоцоог бүрдүүлсэн байна.
- Мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ард иргэдэд мэдээлэл хүргэж хэвшсэн.
- Аймаг бүр иргэний танхимтай болж түүгээр дамжуулж хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний төсөл, бодлогын баримт бичгийн төсөл зэргийг хэлэлцүүлэх, санал авах, орон нутаг дах төрийн байгууллага, нэгж хэлтэс, агентлагууд нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, үйл ажиллагааны танилцуулга зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэвшсэн байна.
- Өргөдөл гомдол, мэдээлэл утас, санал хүсэлтийн хайрцаг зэргээр хүлээн авч хэвшиж өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах сувгийг нэмэгдүүлсэн байна.
- Аймаг бүрт худалдан авах ажиллагааны алба шинээр байгуулагдсанаар худалдан авах ажиллагаатай мэдээллийг олон нийт болон холбогдох байгууллагад хүргэх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу алдаа дутагдалгүй зохион байгуулах талаар тодорхой амжилтанд хүрсэн байна.
- Төсөв, санхүүгийн мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулах зэргээр тодорхой хэмжээнд ил тод байдлыг ханган ажиллаж байна.

ТЭРГҮҮН ТУРШИЛГА

Нийслэл болон аймгуудын ЗДТГ 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж зохион байгуулахдаа бусад байгууллагад авч хэрэгжүүлж болохуйц шинэ оновчтой санал санаачлага гарган ажилласан байгууллагууд цөөнгүй байна. Үүнд:

- Орхон аймаг авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөг АТГ-ын “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу гаргаж ажлыг шат дараалан хэрэгжүүлж, тухайлсан арга хэмжээг тогтмол болгон хэрэгжүүлсэн, нээлттэй ил тод байдлыг хангах, цахим хуудсаны мэдээллийн хөтлөлт баяжуулалт сайн, авлигын эсрэг үйл ажиллагааны санхүүжилтийг хангалттай гарган ажилласан зэргээр 2013 онд авлигын эсрэг үйл ажиллагааг хангалттай түвшинд зохион байгуулжээ.
- Дорнод аймагт иргэд хүлээн авах төв байгуулан засаг даргын шийдвэр, үйл ажиллагааг сурталчилан таниулах, санал, гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авах, тогтмол утас ажиллуулах, үүдэнд байршисан мэдээллийн смарт дэлгэцээр ЗД-ын шийдвэрүүдийг үзэх, холбогдох бүхий л мэдээллийг хүлээн авах боломж бүрдүүлсэн.
- Дорнод аймаг ЗД-ын дэргэдэх агентлаг, сумдуудад хууль, дүрэм журам, дээд шатны байгууллагын шийдвэрээр хүлээсэн үүргийн биелэлт, төрийн

үйлчилгээ ард иргэдэд хүрч байгаа эсэх талаар хяналт шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн шинжээчийн багаар гүйцэтгүүлж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан

- Өмнөговь аймгийн ЗДТГ-ын олон нийттэй харилцах алба нь мэдээ дамжуулах өрөөтэй бөгөөд өөрсдөө мэдээ, мэдээллээ боловсруулж, бичлэг хийх өрөөндөө өөрсдөө бичиж, бичлэгийг ТВ-д өгч цацуулдаг.
- Орхон аймаг 26 иргэний нийгмийн байгууллага, ТББ хамтран ажиллаж төрийн байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлж ажилласан бөгөөд авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах соён гэгээрүүлэх чиглэлээр “Цэвэр төр” ТББ-тай хамтран ажиллажээ.
- Дархан-Уул аймагт Засаг даргын захирамжаар төрийн байгууллагын үйл ажиллагааг үнэ төлбөргүй үзүүлж байна.
- Баянхонгор аймаг өрхтэй харилцах дэвтэр хэвлүүлэн тухайн дэвтэрт иргэн төрийн байгууллагын харилцаанд түгээмэл хэрэглэгдэх хуулийн заалтуудыг түүвэрлэн оруулсан, авлигын эсрэг мэдээллэл, сурталчилгааний хуудсыг арын нүүрэнд байршуулсан, аймаг, сум, багийн удирдлагуудтай холбоо барих утас, төрийн үйлчилгээтэй холбогдсон зөвлөгөөг тусгаж өгсөн байна. Хамгийн чухал нь хууль тогтоомж, аймаг орон нутгаас гаргасан шийдвэртэй танилцаж гарын үсэг зурах, төрийн байгууллагад тус дэвтэрээр дамжуулж санал хүсэлт өгөх боломжийг бүрдүүлж өрх бүрт тараасан байна.
- Дорнод аймгийн худалдан авах ажиллагааны алба худалдан авсан бараа ажил үйлчилгээний явц, чанарын талаар нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэсэн.
- Баян-Өлгий аймагт “Соёлын түшиг” ТББ-тай хамтран авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан жүжигчилсэн тоглолтыг бэлтгэж, 12 сумдаар аялан тоглуулсан бөгөөд орон нутгийн ТВ-ээр иргэдэд хүргэсэн байна.
- Дорноговь аймагт төрийн байгууллагын ажилтаны ажлын үнэлгээг иргэдээс 1-5 хүртэлх оноогоор үнэлүүлж тухайн үнэлгээг харгалзан ажлын үр дүнг үнэлэх, арга хэмжээ авах, шагнал урамшуулал олгоход харгалзан үздэг тогтолцоог нэвтрүүлсэн

ДУТАГДАЛТАЙ ТАЛ

Нийслэл болон аймгуудын ЗДТГ-ууд 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нийтлэг байдлаар дараах дутагдалтай байдал гаргасан байна.

Авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ арга зүйн хувьд дараах алдаа дутагдлыг нийтлэг байдлаар гаргасан байна. Үүнд:

- Төлөвлөгөөг батлахдаа АТГ-аас өмнөх жилүүдэд гаргаж хүргүүлж байсан 4 шалгуур үзүүлэлт бүхий загвар төлөвлөгөөг хуулбарлах байдлаар гаргасан.
- Авлигатай тэмцэх газраас оны эхэнд бүх аймгуудад “төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг хүргүүлсэн

боловч тухайн аргачлалыг харгалзан түүнд уяалдуулж авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж тайлагнан хүргүүлээгүй байна.

- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүг төлөвлөж баталдалдаггүй. Ихэвчлэн ГХУСЗ-ын төсөв, ЗД-ын сангаас шаардагдах хөрөнгийг гаргуулдаг нь гуйврын шинжтэй байна.
- Тогтмол хэрэгжүүлэх ажлыг бүрэн дүүрэн тогтмол болгож хэрэгжүүлэлгүй нэг удаагийн арга хэмжээ болгон өнгөрөөх байдал түлхүү ажиглагдлаа.
- Хуулиар хүлээсэн үүргийн дагуу бусад байгууллагын цахим хуудаст байрлуулсан мэдээллийг мэдээллийн ил тод байдлыг бүрэн дүүрэн хангасан гэж тайлагнах (худалдан авах ажиллагааны зар Www.e-procurement.mn/ төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn/). Өөрийн цахим хуудас бусад мэдээллийн хэрэгсэлээр тухайн мэдээллийг мэдээлэх чиглэлээр идэвхи санаачлагагүй ажиллаж байна.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны агууллагын хувьд дараах нийтлэг дутагдал гаргасан байна. Үүнд:

- Цахим хуудсуудын мэдээлэл дутуу, байх ёстой мэдээллүүд байхгүй, агуулга бүрэн бус, зарим дэд хэсэгт алдаа заадаг, эмх цэгцгүй, иргэд өөрт хэрэгтэй мэдээллийг олж авахад хүндрэлтэй. Жишээлбэл: Дундговь аймгийн албан ёсны цахим хуудсаны худалдан авах ажиллагаа хэсэгт ёгт онигоо байршуулсан.
- Мэдээллийн ил тод байдлыг мэдээллийн самбарт мэдээлэл байршуулснаар хангасан гэж тооцож тайлагнадаг. Бусад мэдээллийн сувгаар нийтэд хүртээлтэйгээр мэдээллийг хүргэх ажил зохион байгуулдаггүй. Мэдээллийн самбар нь олон нийтэд хүрэх хүртээмжийн хувьд төдийлөн хангалттай бус.
- Боловсруулж буй бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх журмын төслийг байршуулж санал авах чиглэлийн ажил дутмаг.
- Мерси Кор ОУБ, АТГ зэргээс зохион байгуулсан сургалтыг авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдээлэл, сургалт хангагдсан гэж тайлагнасан, өөрөө санаачлан бие даан авлигын эсрэг сургалт зохион байгуулаагүй.
- Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн нэр, төрөл тоо, тухайн зөвшөөрлийг авахад бүрдүүлэх материал, хандах албан тушаалтан, мөн тусгай зөвшөөрлийн бүртгэл цахим хуудсанд байршаагүй.
- Иргэн, Иргэний нийгмийн байгууллага, ТББ-тай хамтран ажиллах ажил, санаачлага дутмаг.
- Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт, ёс зүйн дүрмийн хэрэгжүүлэлт, тайлагналт хангалтгүй.
- Авлигад өртөх эсрдэлтэй ажил албан тушаалын жагсаалт гаргаж тухайн ажил албан тушаалд хяналтыг нэмэгдүүлэх, авлига авах боломжийг бууруулах чиглэлээр арга хэмжээ аваагүй.

- Дотоод хяналт шалгалтын болон бусад байгууллагаас явуулсан шалгалтын дүнд илэрсэн зөрчлийн талаарх мэдээлэл дутмаг байна. Энэ талаар нийтэд ил тод мэдээлэхгүй байна.

Дээрх алдаа дутагдалууд нь тухайн байгууллагын удирдлагын санал санаачлага, зохион байгуулалтын алдаа утагдал, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэг хүлээсэн албан тушаалтаны мэдлэг ур чадварын дутагдалтай байдлаас шалтгаалсан болох нь харагдаж байна.

СУДАЛГААНЫ ДҮН

Үнэлгээг хийх явцдаа тухайн байгууллагын удирдлагын авлигын эсрэг үйл ажиллагаанд хандах хандлага, авлигын эсрэг хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг үйл ажиллагааг санхүүжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг тодруулах зорилгоор АТГ-тай хамтран ажилчдаас 5 асуулт бүхий судалгааг ажилчдаас авсан болно.

Судалгаанд Нийслэл болон 21 аймгийн ЗДТГ тус бүрээс 25 хүнийг тус судалгаанд хамруулан асуулгын судалгаа авсан болно. Судалгаанд нийт 517 албан хаагч хамрагдсан нь тухайн байгууллагад ажилладаг нийт ажилчин албан хаагчдийн 56.9 хувийг эзлэж байна. Судалгаанд тухайн байгууллагын ажилчин албан хаагчдийн олонхийг хамруулж чадсан нь судалгааны үр дүнг бодитой гэж үзэх үндэслэл болно.

Нийслэл болон аймгуудын ЗДТГ-ын ажилчин албан хаагчдаас авсан судалгааны дүн

№	Асуулт	Хариулт	Хувь
1	Танай байгууллагын удирдлага 2013 онд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх асуудлаар ажилтануудтайгаа харилцан яриа өрнүүлсэн үү?	А. Байнга	33,6
		Б. Нэг удаа	44,3
		в. Өрнүүлээгүй	21,8
2	Та удирдлагынхаа авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн үнэлдэг вэ?	А. Сайн	55,5
		Б. дунд зэрэг	36,6
		в. Муу	6,1
3	Танай удирдлага таны бодит байдалд нийцсэн, хууль зүйн дагуу бэлтгэсэн саналыг өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу?	А. Байхгүй	64,4
		Б. Хааяа б өөрчилдөг	28
		В. Өөрчилдөг учир би удирдлагаа ашиг сонирхолын талаар зөрчилтэй гэж сэжиглэдэг	5
4.	Танай байгууллагын удирдлага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төсөв, санхүүг баталж өгдөг үү?	А. Тухай бүр баталж өгдөг	31
		Б. Зарим ажлын төсвийг баталдаг	31
		в. Баталж өгдөггүй	32
5	Танай байгууллагын удирдлагаас	А. Тийм	40,1


тухайн жилд баталж, хэрэгжүүлсэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, түүний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнууддаа танилцуулсан уу?	Б. Үгүй	34,7
	В. Мэдэхгүй	26,2

Асуулга 1



Дээрх судалгааны дүнгээс харахад нийслэл болон аймгийн ЗДТГ-уудад ихэнх тохиолдолд авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хурал, цуглаан болон бусад байдлаар ажилчин албан хаагчидадаа мэдээлэл хүргэж хэрэгжилтийн талаар харилцан санал солилцсон байдал харагдаж байна.


Асуулга 2



Дээрх судалгааны дүнгээс үзэхэд аймгуудын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл харилцан адилгүй бөгөөд ажилчдаар сайн гэж үнэлэгдэх нь дийлэнх

байгаа боловч дунд түвшинд үнэлэгдсэн нь багагүй хувийг эзэлж, мөн муу гэж үнэлэгдэх байдал байгаа нь ч анхаарал татаж байна.

Асуулга 3



Судалгаанд оролцогчдын 5 хувь буюу 28 ажилтан албан хаагч өөрийн удирдлагыг өөрийн хуулийн дагуу бэлтгэсэн саналыг өөрчлөдөг, тиймээс удирдлагаа авлига, ашиг сонирхолын зөрчилтэй гэж сэжиглэдэг гэж хариулсан байгаа нь анхаарал татаж байна. Тухайн байгууллагад байгаа зөрчилийг дотор нь ажиллаж байгаа ажилтан албан хаагчид хамгийн ихээр мэдэж, мэдэрэх нь зүйн хэрэг. Нийт судалгаанд оролцогчтой харьцуулахад бага тоо байгаа боловч хариултынх нь чанарыг харгалзаж үзэж анхаарахгүй орхиж болохооргүй байна.

Асуулга 4




Судалгааны тус хэсгийн дүнгээс харахад авлигын эсрэг үйл ажиллагааны санхүүжилт харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь тухайн аймаг орон нутгийн эдийн засгийн чадавхи болон дарга удирдлагын идэвхи санаачлага зэрэг

субъектив нөхцөл байдлаас хамаарч байна.Энэ байдал нь авлигын эсрэг үйл ажиллагааны тайланд ч мөн харагдаж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэн зохион байгуулж байгаа л бол түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө мөнгө төсвийг баталж өгдөг байх шаардлагатай. Иймээс авлигын эсрэг үйл ажиллагааны санхүүжилтийг заавал байх шинжтэй болгох чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь тодорхой болж байна.

Асуулга 5



Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэлтийн тайланг хамт олондоо танилцуулж хэлэлцүүлэн, санал бодлыг нь тусгах чиглэлээр ажиллахгүй байгаа нь дээрх судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэлт гэдэг зөвхөн тухайн ЗДТГ-ын ЭБАТ-ын ажил төдий биш бөгөөд бүх ажилчин албан хаагчдад танилцуулж, тэдгээрийн санал бодлыг төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлэлтийн явцад бүх ажилчин албан хаагчидтай хариуцсан чиглэлтэй нь уялдуулан хамтран ажиллаж байж тухайн ажил үр дүнд хүрч бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой.

Тиймээс авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хамт олноороо хэлэлцүүлдэг, хэрэгжүүлэлтийн явцын талаар танилцуулдаг, жилийн эцэст гүйцэтгэлийг хамт олонд тайлагнадаг тогтолцоог нэвтрүүлдэг байх, энэ байдлыг ч бас үнэлгээний аргачлалын нэг хэсэг болгон оруулахад болохгүй зүйлгүй.

ДҮГНЭЛТ

Нийслэл болон аймгууд авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг нийт 22 байгууллагын төлөвлөгөө, тайлан, холбогдох нотлох баримт, цахим хуудас болон бусад эх сурвалжийг ашиглан үнэлгээ өглөө.

Үнэлгээний дүнг баталгаажуулах, чанаржуулах үүднээс бүс бүрээс нэг аймаг сонгон авч нийт дөрвөн аймаг дээр газар дээр нь ажиллан энэхүү үнэлгээг гүйцэтгэсэн.

Аймгуудаас хамгийн өндөр оноог Орхон аймаг 82 оноотойгоор хамгийн бага оноог Сүхбаатар аймаг 2 оноог авсан байна. Нийслэл болон аймгуудын авлигын эсрэг үйл ажиллагааны дундаж 51,3 гарч байна.

Нийслэл болон аймгуудын ЗДТГ өмнө жилүүдэд өөрсдийн үйл ажиллагааны биелэлт үнэлгээг өөрөө гүйцэтгэж ирүүлж байсан бол 2013 оны хувьд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээг хийлгэж байгаагаар онцлог байлаа.

Аймаг нийслэлийн ЗДТГ-ууд авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөг 2010 оноос хойш гарган тайлагнаж ирсэн учраас ерөнхий байдлаар төлөвшисөн байдалтай байлаа. Гэвч авлигын эсрэг үйл ажиллагаа төлөвлөж зохион байгуулах үүрэг хүлээсэн хариуцсан ажилтан өөрчлөгдсөн байгаа нь төлөвлөгөө тайлан гаргах хэрэгжилтийг зохион байгуулах тал дээр зарим талаар дутуу ажиллах, туршилдаггүйгээ, мэдлэг ур чадвар дутах нөхцөл бүрэлдүүлсэн байна.

Мөн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхдээ өмнөх жилүүдэд ашиглагдаж хэвшсэн дөрвөн тулгуур зарчим бүхий “авлигын эсрэг үйл ажиллагааны загвар төлөвлөгөө”-ний загвараар тухайн загвар төлөвлөгөөг хуулбарлах байдлаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газраас оны эхэнд бүх аймаг нийслэлийн ЗДТГ-д шинээр боловсруулсан “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг хүргүүлэн тухайн аргачлалд уялдуулан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн тайлагнах тухай мэдэгдсээр байтал тухайн аргачлалыг харгалзаж үзээгүй байна.

Тус үнэлгээний аргачлалын үндсэн хэсэг нь тухайн төрийн байгууллагын авлигын эсрэг хууль болон мэдээллийн ил тод байдлыг хангах мэдээлэл авах эрхийн тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад нь үнэлгээ өгч байгаа юм.

Гэвч нийслэл болон аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний оноо бага гарч байгаа нь төрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгааг харуулж байгаа юм.

Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байж авлигын эсрэг оновчтой, үр дүнтэй үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлнэ гэж итгэхэд учир дутагдалтай юм. Тиймээс төрийн байгууллагуудад нэн тэргүүнд тухайн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ ягштал биелүүлдэг байх төлөвшлийг тогтоох нь чухал байна. Үүний тулд тухайн хуулиар үүргээ биелүүлэлгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмийг тухай бүр ашиглан хэрэгжүүлж хэвших ёстой.

Нийслэл болон аймгуудын ЗДТГ 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны дундаж оноо 51,3 гарч байгаа нь дунд гэсэн ерөнхий үнэлгээг авч байна.

Үнэлгээний дүнгээс харахад нийслэл болон аймгуудын авлигын эсрэг үйл ажиллагааг цаашид сайжруулах, хариуцсан ажилтан албан хаагчдыг чадавхижуулах, арга зүйн удирдлагаар хангах, үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хуульд заагдсан хариуцлагын механизмийг хэрэглэх, нөгөө талаар авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ололт амжилт гаргасан тохиолдолд урамшуулах, үнэлгээний дүнгээс хамгийн бага оноо авсан ажлуудыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн байдлаар зөвлөмж, удирдамж гарган хүргүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Нийт 48 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн, нэгж байгууллагын 2013 онд хэрэгжүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт өглөө.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн, нэгжүүд авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан хэрэгжүүлэхдээ дутуу дулимаг хандсан, хэлбэрийн төдий төлөвлөгөө, тайлан гаргаж ирүүлсэн бөгөөд холбогдох нотлох баримтыг хавсралтаар хүргүүлж ирүүлээгүй байгаа нь үнэлгээг өгөхөд хүндрэлтэй байсан.

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс бусад аж ахуйн, нэгжүүд холбогдох нотлох баримтыг дутуу ирүүлсэн тул тайланд хийж гүйцэтгэсэн гэж тайлагнасан ажлын харгалзах оноог өгсөн болно.

Авлигатай тэмцэх газартай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн, нэгж байгууллагуудад үнэлгээ өгөхдөө “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын 7.1.1, 7.1.4, 7.1.5, 7.1.7 дахь хэсгүүдийг үнэлээгүй бөгөөд уг хэсгүүдэд тусгагдсан оноог нэмж, нийлбэр оноог гаргасан.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн албан ёсны цахим хуудсанд мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллүүд болох санхүү, төсөв, хүний нөөц, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг дутуу байршуулсан бөгөөд цахим хуудас хөтлөлт муу байсан нь үнэлгээг бууруулж үнэлэхэд хүргэж байна.

Мөн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013.06-2013.07 сард буюу хагас жил өнгөрсний дараа батлан гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн нь учир дутагдалтай байсан боловч тухайн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлаар нь харгалзах оноог өгсөн болно

Д/д	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага	Оноо
1.	“ШИВЭЭ ОВОО” ХК	69
2.	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК	64
3.	ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК	58
4.	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК	58
5.	ҮЦТТХ-ын төв ХХК	57
6.	Эрдэнэт-Булганы ЦТС ТӨХК	53
7.	БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК	52
8.	Цахилгаан түгээх үндэсний сүлжээ ТӨХК	51
9.	“БАГАНУУР ДС” ТӨХК	47
10.	Хөдөө аж ахуйн бирж	43
11.	МИАТ ХК	42
12.	Дорнод бүсийн эрчим хүч	40
13.	ДЦС-4	39
14.	Улаанбаатар төмөр зам	38
15.	Уламжлалт анагаах ухаан, технологи үйлдвэрлэлийн корпораци	38
16.	ДЦС-3	37
17.	Монголын Төмөр зам	35
18.	БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ	34
19.	Хараагүйчүүдийн хөдөлмөр сургалтын үйлдвэр	32
20.	Эрдэнэс МГЛ	32
21.	УБЦТС	31
22.	Дарханы дулаан сүлжээ	31
23.	ЗУРАГ ТӨСӨЛ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИНСТИТУТ УТҮГ	28
24.	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	28
25.	Монгол кино	25
26.	Сайн шанд аж үйлдвэрийн парк	25
27.	Хөтөлийн цемент шохой	24
28.	Биокомбинат	24
29.	Хөгжлийн банк	24
30.	ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОР	23
31.	Дорноговь АЗЗА	23
32.	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв	23
33.	Мэдээлэл холбооны сүлжээ	22
34.	Диспечерийн үндэсний төв	20
35.	Булган АЗЗА	20
36.	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ	19
37.	Шарын гол ХХК	17
38.	Төрийн Банк	16
39.	Эрдэнэс таван толгой	16
40.	Цагаан шонхор	14
41.	Авто-импекс	14
42.	ДЦС-2	12

43.	Багануур ХК	12
44.	Монгол шуудан	11
45.	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж	10
46.	Булган аймгийн Цөм сүрэг үржлийн аж ахуй	5
47.	Өмнөговь аймгийн цөм сүрэг үржлийн аж ахуй	3
48.	Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээ	0
Дундаж оноо		29,3

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Үнэлгээний үр дүнг нэгтгэн байгууллага бүрийн тухайн шалгуурт авсан оноо гүйцэтгэлийн хувийг гарган тооцож нийт 48 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд дүн шинжилгээ хийж ажилласан болно. (Хавсралт-4)

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны биелэлтийн хувийн дундаж 26,6 хувьтай гарч байна.

Авлигын эсрэг хэрэгжүүлсэн ажлын төрлөөр нь биелэлтийн хувийг гаргавал дараах байдлаар үнэлгээ авч байна.

- ЭБАТ-ын үйл ажиллагаатай холбоотой ажлуудаас- 46,9%
- Дотоод хяналт, зохион байгуулалттай холбоотой ажлаас- 33,2%
- Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлийн ажлуудаас-28,8%
- Иргэний нийгэмийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр-4,3%
- АТГ-ын зөвлөмж, албан бичгийн биелэлт-43,6%
- Удирдлагын авлигын эсрэг хүчин чармайлт, идэвхи-18,6%
- Өргөдөл, гомдол хүлээн авах боломж бүрдүүлэлт, шийдвэрлэлт- 22,3%

Хамгийн сайн биелэлтийн хувьтай ажлууд

- ✓ Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийн байдал-73,4%
- ✓ Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт-86,2%
- ✓ Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах-66%
- ✓ Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байдал-48,9%
- ✓ Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байдал-40,4%
- ✓ Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байдал-57%
- ✓ Эрх бүхий албан тушаалт-ныг томилсон байдал-50%
- ✓ Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дү-рэм, журам, зааврын нээлт-тэй байдал -42,6%
- ✓ Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал-54,3%

- ✓ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний үр дүн-53,2%

Хамгийн муу биелэлтийн хувьтай ажлууд

- Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал-3,3%
- Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ -8,7%
- Тухайн жилийн төсөв ,өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл ийг цахим хуудсанд байршуулсан байдал-12,8%
- Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлсэн байдал-7,4%
- Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсан-даа ойлгомжтой байдлаар байршуулсан байдал-9,6%
- Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажилласан байдал, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн -4,3%
- Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байдал-2,1%
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал-11,7%
- Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал-12,5%

ОЛОЛТ, АМЖИЛТ

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд 2013 онд авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ дараах нийтлэг амжилтанд хүрсэн байна. Үүнд:

- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн, нэгж байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг өөрийн байгууллагын онцлогт тохируулан баталж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байгаа нь сайшаалтай юм.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зарыгцахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагууд өөрийн байгууллагад ЭБАТ-ыг томилж, ХОАСМ-ийг бүртгэх, хадгалах, хянах, авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг ажлын байрын тодорхойлолтонд тусгасан нь Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлж байна.

ТЭРГҮҮН ТУРШИЛГА

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд 2013 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг

хэрэгжүүлэхдээ дараах оновчтой санал, санаачлагыг гарган хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК “Авлигын эсрэг хамтдаа” мэдээллийн самбар ажиллуулж Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сурталчилгаа байршуулан, авлига ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон гомдол, мэдээлэл хүлээн авах хайрцаг байршуулсан.
- МИАТ нь байгууллагын албан ёсны цахим хуудсанд хэрэглэгчийн дуу хоолой булан ажиллуулдаг бөгөөд тус цахим хуудсаар бүх төрлийн гомдол, мэдээллийг хүлээн авах боломж,бололцоог бүрдүүлсэн.
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь “Ёс зүйн зөрчлийг мэдээллэх “мэдээллийн самбар” ажиллуулж байна.
- МИАТ нь Ёс зүйн асуудал эрхэлсэн ажилтны ажлын байрыг бий болгож, байгууллагын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, ёс зүйн чиглэлээр сургалт, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж байна.
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-ийг аялуулж, нийт ажилчдаар гарын үсэг зуруулсан бөгөөд Авлигагүй ажлын байр хөтөлбөр хэрэгжүүлэн байгууллагын удирдлагаас авлиггүй хамт олон болох тухай уриалга гаргасан.

ДУТАГДАЛТАЙ ТАЛ

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгуулагууд авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах нийтлэг дутагдал гаргасан. Үүнд:

- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухайлсан төсөв, санхүү баталдаггүй.
- Байгууллагын удирдлагын зүгээс Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал санаачлага гаргадаггүй.
- Хариуцсан ажилтан болон ЭБАТ-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах болон төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах мэдлэг, мэдээлэл дутмаг.
- Төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхдээ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн үнэлгээний аргачлыгудирдлага болгон хэрэгжүүлээгүй.
- Ихэнхи аж ахуйн нэгж, байгууллага Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013.06-2013.07 дугаар сард буюу хагас жилээс хойш батлан хэрэгжүүлсэн байна.
- Төлөвлөгөө болон төлөвлөгөөний тайланг ерөнхий болоод товчбайдлаар гаргаж ирүүлсэн.
- Төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг ирүүлэхдээ хийж гүйцэтгэсэн ажлыг нотлох холбогдох нотлох баримтуудыг хавсралтаар дутуу ирүүлсэн.
- Төсөв, санхүүгийн тайлангийн нээлттэй байдлыг хангаагүй.
- Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг хангалтгүй хэрэгжүүлсэн.
- Нэр бүхий байгууллагын цахим хуудас дахь мэдээлэл нь мэдээллийн ил тод байдлыг хангалттай хэмжээнд хангаж чадахгүй, цаг хугацааны хувьд үнэ цэнээ алдсан байна.

- Зарим байгууллага нь албан ёсны цахим хуудас ашиглахгүй байгаа ба бусад цахим хэрэгсэл /блог, фасебүүк гэх мэт/ ашиглаж байна.
- Иргэд, үйлчлүүлэгчдээс өргөдөл, гомдол хүлээн авах механизмыг бүрдүүлээгүй.
- Хүний нөөцийн бүрдүүлэлт, удирдлагын ил тод байдал, шинэ ажлын байрны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлдэг.
- Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тодорхой судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгүүлэх уялдаа, холбоо байхгүй.
- Удирдлагаас гарч буй шийдвэрийн нээлттэй байдлыг хангалттай хэрэгжүүлдэггүй.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 28 аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтны “авлигын эсрэг санал, санаачлага”-ыг илтгэх зорилго бүхий асуулгын судалгааг тухайн байгууллагын ажилчдаас авч үр дүнг нэгтгэсэн болно.

Асуулгын судалгаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 28 аж ахуйн нэгж, байгууллага оролцсон нь нийт үнэлэгдэж буй байгууллагын 50 хувийг хамарсан.

Харин асуулгын судалгаанд нийт 538 ажилтан, албан хаагч хамрагдсан нь тус байгууллагуудын нийт ажилчид, албан хаагчдын 36,1 хувийг хамарч байна.

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГААС АВСАН СУДАЛГААНЫ ДҮН

№	Асуулт	Хариулт	Хувь
1	Танай байгууллагын удирдлага 2013 онд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх асуудлаар ажилтануудтайгаа харилцан яриа өрнүүлсэн үү?	А. Байнга	14
		Б. Нэг удаа	37
		в. Өрнүүлээгүй	48
2	Та удирдлагынхаа авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн үнэлдэг вэ?	А. Сайн	45
		Б. дунд зэрэг	38
		В. Муу	13
3	Танай удирдлага таны бодит байдалд нийцсэн, хууль зүйн дагуу бэлтгэсэн саналыг өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу?	А. Байхгүй	71
		Б. Хааяа өөрчилдөг	20
		В. Өөрчилдөг учир би удирдлагаа ашиг сонирхолын талаар зөрчилтэй гэж сэжиглэдэг	6,4

4.	Танай байгууллагын удирдлага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төсөв, санхүүг баталж өгдөг үү?	А. Тухай бүр баталж өгдөг	26
		Б. Зарим ажлын төсвийг баталдаг	30
		в. Баталж өгдөггүй	32
5	Танай байгууллагын удирдлагаас тухайн жилд баталж, хэрэгжүүлсэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, түүний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнууддаа танилцуулсан уу?	А. Тийм	32
		Б. Үгүй	30
		В. Мэдэхгүй	40


Асуулга 1.



Тус судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар ажилчидтайгаа хамтран ажиллах хамтын ажиллагаа сул байна.

Асуулга 2.


Та удирдлагынхаа авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн үнэлдэг вэ?



Судалгааны үр дүн харьцангуй байдлаар гарсан боловч дунд болон муу гэсэн үнэлгээ дийлэнх олонхийг эзлэж байна.

Асуулга 3.

Танай удирдлага таны бодит байдалд нийцсэн, хууль зүйн дагуу бэлтгэсэн саналыг өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу?



Дээрх судалгааны үр дүнгээс харахад хууль зүйн дагуу бэлтгэсэн аливаа саналыг өөрийн болон бусдын ашиг сонирхолын үүднээс өөрчилсөн тохиолдол байхгүй гэж судалгаанд оролцогчдын 71 хувь нь хариулсан байна. Энэ нь судалгаанд хамрагдаж байгаа байгууллага хувийн салбарт үйл ажиллагаа явуулдаг учраас бусдад эрх, үүрэг олгосон шийдвэр гаргах тохиолдол харьцангуй бага байдагтай холбоотой. Гэвч мөн л удирдлагаа сэжиглэдэг гэх хариултыг судалгаанд хамрагдсан 46 хүн хариулсан бөгөөд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагаас авлигын гэмт хэрэгтэй холбогдуулан 2013 оны хувьд 12 эрүүгийн хэрэг үүсгэсэн нь тухайн салбарт авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх магадлал өндөр байгаа харуулж байна.

Иймээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх,

чанаржуулах, авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгааг харуулж байна.

Асуулга 4.




Судалгааны үр дүн, үзүүлэлт бүр ойролцоо хувьтай гарсан байгаа нь мөн л тухайн байгууллагын ашиг орлого, удирдлагын хүсэл эрмэлзэлээс хамааран авлигын эсрэг үйл ажиллагаанд хөрөнгө мөнгө зарцуулах эсэх нь шийдэгддэг байдал байгааг харуулж байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага авлигын эсрэг үйл ажиллагаанд хөрөнгө мөнгө төсөвлөн зарцуулах нь тухайн байгууллага дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс болж хүлээх алдагдлаас ямагт бага байх боломжтой юм.

Иймээс тухайн аж ахуй нэгж байгууллага төдийгүй, Төрийн өмчийн хороо, АТГ-аас авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө төсвийг тухайн байгууллагын жилийн төсөв төлөвлөгөөнд тогтмол оруулж байх чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байна.

Асуулга 5.



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэхдээ ажилчиддаа танилцуулдаггүй байдал нь уг судалгааны дүн харуулж байна.

Мөн үнэлгээ хийх явцад ч дээрх байдал ажиглагдсан бөгөөд оны хагас өнгөрч байхад богино хугацаанд, хэт ерөнхий төлөвлөгөө гаргаж, түүнийгээ тайлагнан ирүүлсэн.

Тиймээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын ЭБАТ-уудыг авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах Ерөнхий арга аргачлалд сургах нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 48 байгууллагын 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ өгч ажиллаа.

Үнэлгээний дүнг баталгаажуулах зорилгоор санамсаргүй сонголтоор хөдөө орон нутаг дахь хоёр, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг гурав, нийт таван төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад газар дээр нь ажилсан.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудаас 48 байгууллага авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан тайлагнасан нь тодорхой амжилтанд хүрч байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудаас 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд өндөр оноог “Шивээ овоо” ХК/66 оноо/, бага оноог Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК /0 оноо/ авсан байна. Харин нийт үнэлгээний дундаж оноо нь 30 оноо гарсан байна.

Гэвч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлсэн ажлын чанар, үр дүн төдийлөн хангалттай бус байна. Төлөвлөгөөг боловсруулж гарахдаа хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг тусгаагүй, цөөн тооны ажлуудыг төлөвлөсөн бөгөөд уг төлөвлөгдсөн ажлыг хийж, хэрэгжүүлсэн хэмээн тайлагнасан. Төлөвлөгөөг хугацааны хувьд оройтож батлан ирүүлсэн, тайлан ирүүлэхдээ гүйцэтгэсэн ажлыг нотлох холбогдох нотлох баримтыг хавсаргаж ирүүлээгүй зэрэг алдаа дутагдлууд гарсан.

Мөн албан ёсны цахим хуудас дахь мэдээлэл хангалтгүй, мэдээлэлийн ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заагдсан санхүү, хүний нөөц, худалдан авах ажиллагааны тухай мэдээллүүдийг байршуулаагүй, зарим байгууллагууд цахим хуудасгүй байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Тиймээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн, нэгжүүдэд нэн тэргүүнд мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим хуудасны хөтлөлтболоод нээлттэй байх мэдээллүүдийг байршуулан шинэчилж занших шаардлагатай байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний дундаж оноо 29,1 байгаа ба энэ нь хангалтгүй үзүүлэлт юм.

Үнэлгээний дүн хангалтгүй гарч байгаа нь ихэнх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж% байгууллага авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайланг анх удаа гарган ирүүлсэн, хариуцсан ажилтан албан тушаалтаны мэдлэг мэдээлэл, туршилга хангалтгүйгээс шалтгаалсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн удирдлагын авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаар хүсэл эрмэлзэл хангалтгүй.

Иймээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахын тулд хариуцсан ажилтан, албан тушаалтныг холбогдох сургалтанд хамруулан мэрэгшүүлэх, дарга болоод удирдлагын авлигын эсрэг үйл ажиллагааны санал санаачлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2013 оны хувьд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан тушаалтанд 12 эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа нь тухайн салбарт авлига, ашиг сонирхолын зөрчил өндөр байгаа харуулж байна.

Иймээс АТГ-аас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд уруу анхаарлаа хандуулан авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, чанаржуулах, авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгааг харуулж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Шинжээчдийн багаас Нийслэл болон аймгуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх явцад тэдгээрийн гаргаж буй нийтлэг алдаа дутагдал, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг өөрсдийн шинжилгээ, судалгаа, ажиглалтын явц, үр дүнг үндэслэн тодорхойлж, тэдгээрийг арилгах, засан сайжруулах, цаашид авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх үүднээс

арга зүйн хувьд үнэлгээнд хамрагдаж буй байгууллага болон Авлигатай тэмцэх газарт хандсан санал, зөвлөмжийг өгч байгаа болно.

НИЙСЛЭЛ БОЛОН АЙМГУУДЫН ЗДТГ-Т

Нийслэл болон аймгуудын ЗДТГ нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхдээ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг удирдлага болгох.
- Төлөвлөгөө боловсруулахын өмнө өөрийн орон нутагт авлига гарах боломж бүрдүүлж буй шалтгаан нөхцлийг тодруулах талаар иргэний нийгмийн байгууллагаар судалгаа хийлгэж, тухайн нөхцөл шалтгааныг арилгах чиглэлд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж ажиллах, тус орон тооны бус зөвлөлөөр авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг сар бүрдүгнэж байх.
- Авлигын эсрэг төлөвлөгөөгөөр тухайлан үүрэг хүлээсэн ажилтан хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага тооцдог байх.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хамт олоноороо хэлэлцүүлэн хэрэгжилтийн талаар танилцуулдаг, жилийн эцэст гүйцэтгэлийг нь хамт олонд тайлагнаж хэвших.
- Өөрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний дүгнэлт гаргаж, хангалтгүй хэрэгжүүлсэн ажлыг сайжруулах чиглэлийг дараа жилийн төлөвлөгөөг гаргахдаа харгалзан үзэх.
- Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхдээ сум, харъяа агентлагуудын авлигын эсрэг төлөвлөгөөтэй уялдуулах.
- Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтэнд дотоод хяналтын нэгж давхар хяналт тавьдаг байх;
- Төлөвлөгөөний төслийг боловсруулан АТГ-аас санал, зөвлөмж авах

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-аас хүргүүлсэн үнэлгээний аргачлалтай уялдуулан өөрийн байгууллагад хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.
- Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх, цахим хуудас дахь мэдээллийг шинэчлэн баяжуулж, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулах
- Авлигын эсрэг хууль тогтоомжийг нийт ажилчид, албан хаагчдад сурталчлах, мэдээллэх ажлыг бодитой хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах.

- Худалдан авах ажиллагааны үнэлгээний комисст хөндлөнгийн иргэн, ТББ-ын төлөөлөл оролцуулж хэвших.
- Иргэд, хэрэглэгчээс гомдол, мэдээлэл хүлээж авах тогтмол утас ажиллуулах, гомдол мэдээлэл бүртгэх, хянах, хариу өгөх механизмыг боловсронгуй болгох.
- Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн нээлттэй ил тод байдлыг хангах.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны зохион байгуулалт, хамрах хүрээ, үр дүн нэмэгдэх тулд авлигын эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих эрх, үүргийнхээ хүрээнд дараах арга ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтнуудыг нэгдсэн байдлаар “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тайлагналт”-тай холбогдсон сургалтанд хамруулж, идэвхижүүлэх;
- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хангахад шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, орон нутгийг хөгжүүлэх сангийн төсөв, төрийн өмчит аж ахуй нэгжийн жилийн төсөвт тусган тогтмол санхүүжүүлэх талаар зөвлөмжийг Аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад хүргүүлэх;
- Байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтан /IT инженер/-үүдийг мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн ил тод байдал мэдээллэл авах эрхийн тухай хуулийн чиглэлээр сургалтанд хамруулах;
- Цахим хуудсын хөтлөх мэдээллийг баяжуулах чиглэлээр хангалтгүй ажилласан, мэдээллийн ил тод байдлын тухай болон Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд тус хуульд заасан хариуцлагын зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр тэргүүн туршлага нэвтрүүлсэн байгууллагын үйл ажиллагааг бусад байгууллагуудад хүргэн мэдээлж сурталчилах, боломжит зарим тэргүүн туршлагыг хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг хүргүүлэх;
- Үнэлгээний хүснэгтийн дагуу хэрэгжүүлээгүй ажлуудыг 2014 онд сайжруулан хэрэгжүүлэхийг тухайн байгууллагад даалгах;
- “Төрийн байгууллагын авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулах (Яам, агентлаг, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоот аж ахуй нэгж байгууллагад) зарим шалгуур хэсгийг тодорхой болгох, сайжруулах
- Авлигад өртөх эрдэлтэй ажил, албан тушаалын судалгаа хийх, жагсаалт гаргах, тухайн байгууллагад тусгайлсан хяналтыг зохион байгуулах чиглэлээр арга зүйн хувьд зөвлөмж өгөх;

Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг сайжруулах чиглэлээр

- Үнэлгээний аргачлалын 7.1.2-ийн 3 дэх хэсэгт заасан “Авлигын эсрэг соён гэгээрүүлэх авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрсэн үр дүн” тус аргачлалын 7.1.12-ийн 5 дах хэсэгт заасан “ЭБАТ-ны ажлын үр дүнгийн байдал” гэж утга агуулгын хувьд давхардсан зүйлүүдийг арилгах.
Мөн тус ажлын үр дүнг ямар үзүүлэлтээр тооцохыг тодорхой болгох(Авлигын гэмт хэрэг, зөрчлийн бууралт, өргөдөл гомдлын тоо хэмжээ буурах гэх мэт)
- Үнэлгээний аргачлалын 7.1.5 “Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах” үзүүлэлт дэх төрийн хяналт шалгалт гэсэн ойлголтонд мэргэжлийн хяналтын шалгалт, ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсийн хяналт шалгалт, аудитын хяналт, шалгалтуудын аль хяналт, шалгалтын алийг багтааж байгаа эсвэл тус хяналт шалгалтуудыг бүгдийг нь багтаах эсэхийг тодорхой болгох, үнэлгээний аргачлалд нэрлэн заах;
- Үнэлгээний аргачлалын 6.1.6 “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төл-бөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилсэн байдал” гэсэн шалгуурын ач холбогдол ямар байх, хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх эсэхийг хянаж үзэх,
- Үнэлгээний аргачлалын 7.17-д заасан “Хуулиар хориглоогүй бүртгэ-лийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/” гэдэгт ямар бүртгэлийн хөтлөлтөөр үнэлэх талаар тодорхой болгож өгөх
- Үнэлгээний аргачлалын 7.1.13-д заасан “ Ёс зүйн зөрчлийн талаарх, тайлан, мэдээг АТГ-т ирүүлсэн байдал” шалгуураар үнэлэхийн тулд ёс зүйн

зөрчлийн мэдээг төрийн албаны зөвлөлөөс гадна АТГ-д ирүүлсэн байх талаар мэдэгдэл хүргүүлэх

- Үнэлгээний аргачлалын 7.1.15-д заагдсан “Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал /цахим хуудас, мэдээллийн самбар/” шалгуурын эрх бүхий албан тушаалтан гэж яг ямар субъектийг нэрлэж байгаагаа тодорхой болгох 7.1.15-ын 2 дах хэсэгт заасан шалгуурын “гаргасан” гэдэг нөхцөлөөс хэрхэн ялгаж буйг тодорхой болгох, дотоодод, хүний нөөцийн чиглэл, тухайлсан этгээдэд эрх олгох гэх мэт өдөр тутмын шинжтэй бүхий л шийдвэрийн төслийг ил тод нээлттэй мэдээлэх эсэхийг харгалзан үзэх
- Үнэлгээний аргачлалд авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг ажилчдаар хэлэлцүүлэн саналыг тусгасан байх, сар бүр хэрэгжилтийг үнэлэж хэлэлцсэн байх, тайланг ажилчид албан хаагчдад танилцуулсан байх гэсэн шалгуур оруулах;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын авлигын эсрэг явуулсан үйл ажиллагааг тухайн байгууллагын онцлогийг харгалзан “компанийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” “Байгууллагын нууцын тухай хууль” зэрэгтэй уяалдуулан үнэлгээний бие даасан аргачлал боловсруулж түүний дагуу үнэлгээг хийдэг байх;

ХАВСРАЛТ

- Байгууллагуудын үнэлгээний хуудас
- Байгууллагуудаас авсан судалгааны нэгтгэл
- Үнэлгээний хуудсанд хийсэн шинжилгээ
- Байгууллагуудад газар дээр нь ажилласан тухай тайлан

Ашигласан материал, эх сурвалж

Нэг. Хууль тогтоомж

- ✓ Авлигын эсрэг хууль
- ✓ Нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхолын зөрчлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль

Хоёр. Баримт материал

- ✓ “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”
- ✓ Байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллаганы төлөвлөгөө тайлан, хавсралтаар ирсэн нотлох баримтууд,
- ✓ Байгууллагын цахим хуудас,
- ✓ Газар дээр нь ажиллаж гаргуулан авсан баримт, нотолгоо,
- ✓ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн бүртгэл,
- ✓ Авлигатай тэмцэх газраас авагдсан зөрчил арилгуулах, хариуцлага оногдуулсан арга хэмжээний бүртгэл,

- ✓ Тухайн байгууллагуудтай холбогдох авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл гомдолын бүртгэл,
- ✓ Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагын албан тушаалтанаас авлигатай тэмцэх газарт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа бүртгэлийн тоо мэдээ,
- ✓ Асуулгын судалгааны дүн,
- ✓ Төрийн албаны зөвлөл болон худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас